



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/1091

Есөнбулаг


Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Тайшир сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Д.Батнайрамдал	(Аймгийн Худалдан авах ажиллагааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	З.Жаргалтуяа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	А.Доржготов	(Иргэний нийгмийн төлөөлөл) (тохиролцсоноор)
Нарийн бичиг:	Д.Пунсалмаа	(Есөнбулаг сумын иргэн)
	Д.Нарандулам	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Б.Батнайрамдал)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ